

ХААН БАНК ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04 дүгээр
сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

ХААН Банк ХК (“Банк”, “ХААН Банк” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 сарын 24-ний өдөр 14:00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж-25 хаягт байрлах ХААН Банкны оффисын 1 давхарт, ХААН Театрт хуралдав.

ХУРАЛД ОРОЛЦСОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

1,648,602,347 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 262 хувьцаа эзэмшигч хуралд (цахим болон танхим) оролцов.

ХУРЛЫН ДАРГА

ХААН Банкны ТУЗ-ийн дарга Т.Дарьбум нь энэхүү хурлыг даргалан хуралдуулав.

ИРЦ

Тооллогын комиссын дарга Б.Онон хурлын ирцийг танилцуулав.

Нийт 1,648,602,347 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа 262 хувьцаа эзэмшигчид хуралд оролцохоор бүртгүүлсэн (цахим болон танхим) нь нийт саналын эрх бүхий 1,912,198,000 ширхэг энгийн хувьцааны 86.22 хувь болохыг мэдээлэв. Иймд, Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дахь хэсэг, ХААН Банк ХК-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.14 дэх хэсгийг тус тус үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 86.22 хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигчид хуралд оролцсон тул ХААН Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцов.

ТАНИЛЦУУЛАХ АСУУДАЛ:

- 1.1 “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
- 1.2 “ХААН Банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсан тухай тайлан;
- 1.3 “ХААН Банк” ХК-ийн 2025 оны чанаргүй активыг холбогдох эрсдэлийн сангаас хорогдуулсан тайлан;
- 1.4 “ХААН Банк” ХК-ийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлт;
- 1.5 “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлангийн танилцуулга;
- 1.6 “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийн танилцуулга;
- 1.7 “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга.

ХЭЛЭЛЦЭН БАТЛУУЛАХ АСУУДАЛ:

- 2.1. “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
 - 2.2. “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсөв;
 - 2.3. “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг сонгон томилох
- Т.Дарьбум хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж, хурлын хөтөлбөр, дэгийг танилцуулав.

ТАНИЛЦУУЛСАН НЬ: “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан

ХААН Банкны Гүйцэтгэх Захирал Р.Мөнхтуяа “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлаг танилцуулав.

ТАНИЛЦУУЛСАН НЬ: “ХААН Банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсан тухай тайлан

ХААН Банкны Гүйцэтгэх Захирал Р.Мөнхтуяа “ХААН Банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсан тухай тайланг танилцуулав.

ТАНИЛЦУУЛСАН НЬ: “ХААН Банк” ХК-ийн 2025 оны чанаргүй активыг холбогдох эрсдэлийн сангаас хорогдуулсан тайлан

ХААН Банкны Гүйцэтгэх Захирал Р.Мөнхтуяа “ХААН Банк” ХК-ийн 2025 оны чанаргүй активыг холбогдох эрсдэлийн сангаас хорогдуулсан тайланг танилцуулав.

ТАНИЛЦУУЛСАН НЬ: “ХААН Банк” ХК-ийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлт

ПрайсУотерхаусКуперс Аудит ХХК-ийн Санхүүгийн Үйлчилгээний салбарын Аудитын Партнер Айгуль Ахметова болон Аудитын Менежер С.Энх-Уян нар “ХААН Банк” ХК-ийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлтийг танилцуулав.

ТАНИЛЦУУЛСАН НЬ: “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлангийн танилцуулга

ХААН Банкны ТУЗ-ийн нарийн бичгийн дарга В.Янжинлхам “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны ажлын тайланг танилцуулав.

ТАНИЛЦУУЛСАН НЬ: “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийн танилцуулга

ХААН Банкны ТУЗ-ийн нарийн бичгийн дарга В.Янжинлхам “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг танилцуулав.

ТАНИЛЦУУЛСАН НЬ: “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт

ХААН Банкны ТУЗ-ийн дарга Т.Дарьбум “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулав.

ТАНИЛЦУУЛСАН НЬ: “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга

ХААН Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хорооны дарга Ханс Аарт Йонгеганс “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдэд танилцуулах асуудлууд дуусч хөтөлбөрийн дагуу асуулт хариултын хэсэгт шилжсэнийг мэдэгдэв.

АСУУЛТ ХАРИУЛТ:

Асуулт №1: Залуучуудын оролцоог нэмэгдүүлэхэд баримтлах бодлого болон Банкны бүтцэд залуучуудын зөвлөх хороо байгуулах зорилго байгаа эсэх? Мөн 18-35 насны залуу үеийн төлөөллүүд нийт ажилтан болон удирдлагын багийн хэдэн хувьд ажилладаг вэ?

Хариулт (Р.Мөнхтуяа): ХААН Банк ХК-ийн 5800 гаруй ажилтны 65 хувь нь эмэгтэйчүүд, 35 хувь нь эрэгтэйчүүд байна. 18-35 насны залуучуудын хувьд нийт ажилтны 70 орчим хувийг эзэлдэг. Банкинд ажилтнуудын эрхийг хамгаалсан үйлдвэрчний хороо, гэр бүлийн буюу эцэг эхчүүдийн хороо, ахмадын хороо байгуулан ажиллаж байна. Мөн 35 наснаас доош насны залуус, эмэгтэйчүүд дийлэнх хувийг эзэлдэг учир бид хүүхэд асрах чөлөөнд сууж байгаа ээжүүдэд зориулан 2 аппликэйшнаар дамжуулан сургалт, хөгжлийн хөтөлбөр явуулдаг. Өнөөдрийн байдлаар банканд 712 төрлийн ажлын байр байна. Эдгээрт шаардагдаж буй ур чадварыг ангилж зайнаас ажиллаж болох эсэх ямар давтамжтай хийж болохыг анхааран судалж байна.

Асуулт №2: 2026 оны санхүүгийн төлөвлөгөө, татан төвлөрүүлсэн хөрөнгө (ТТХ)-ийн гадаад болон дотоод зах зээлийн зорилт, ТТХ-ийн хүү, болон 2026, 2027 онуудын цэвэр хүүгийн маржин? Хиймэл оюун ухааны хөгжил, автоматжуулалт, ажиллах хүчний орон тоо, хэмнэлт?

Хариулт (Р.Мөнхтуяа): 2026 оны бизнес төлөвлөгөөг 2025 оны 11 сарын ТУЗ-ийн хурлаар баталсан. Тус төлөвлөгөөний дагуу татварын дараах цэвэр ашгийг 708 тэрбум төгрөгт хүргэх, нийт хөрөнгө, ТТХ, зээлийн багцыг 14-15 хувийн өсөлттэй байхаар төлөвлөсөн. Зээлийн багцад эзлэх бизнесийн зээлийн хувь хэмжээг 53-54 хувь хүргэхээр ажиллаж байна. Гадны эх үүсвэрийн хүү нь МУ-ын зээлжих зэрэглэл, зориулалт, SOFR хүү болон банкны эрсдэлээс хамааран ялгаатай тогтдог. Ихэвчлэн арилжааны зээлийн хүүнээс 1-2 хувийн бага байдаг тул эдгээр эх үүсвэрээр олгох зээл нь нийгэм, ногоон, эмэгтэй бизнес эрхлэгч зэрэг тогтвортой хөгжлийн чиглэлд зориулагддаг. 2026 он бол дунд хугацааны бизнес төлөвлөгөөний сүүлийн жил ба бид хиймэл оюун ухаанд суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, үйлчилгээний хурд, чанарыг сайжруулахад үргэлжлүүлэн анхаарч байна. Дижитал банк болохтой холбогдуулан орон тоо цөөрүүлэх, салбар нэгжийг татан буулгах бодлогыг баримтлахгүй байгаа. Харин бид бизнесээ илүү тэлж, орлогоо нэмэгдүүлэх замаар ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, тогтвортой ажлын байраа хадгалах зорилго тавин ажиллаж байна.

Асуулт №3: Энэ онд Банкны тухай хуулийн 20 хувийн эзэмшлийг шаардлагыг билүүлэхээр байна. Үүний дагуу ТУЗ-ийн түвшинд хийж буй ажлууд, зорилго, зорилт ямар байгаа вэ?

Хариулт (Т.Дарьбум): Өмнөх хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу ТУЗ, Удирдлага болон хувьцаа эзэмшигчид улирал бүр хуралдаж, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид өөрсдөө хөрөнгө оруулагч олно гэж шийдвэр гаргасны дагуу ажиллаж байна. Нарийвчлан мэдээлэл авахыг хүсвэл хувьцаа эзэмшигчдийн төлөөллүүдээс асуух боломжтой.

Хариулт (Р.Мөнхтуяа): Банкны зүгээс сайн хувьцаа эзэмшигч олоход дэмжлэг үзүүлэх, банк санхүүгийн чиглэлд үйл ажиллагаа явуулж буй хөрөнгө оруулагчдыг хувьцаа эзэмшигчидтэй уулзуулах ажлыг хийж байна. 2025 онд батлагдсан төлөвлөгөөний дагуу улирал бүр удирдлага, ТУЗ-ийн дарга, хувьцаа эзэмшигчид уулзаж хуулийн шаардлагыг биелүүлэхээр ажиллаж байна.

Асуулт №4 (цахим): Банкны үйл ажиллагаанд дунд хугацааны эрсдэл боломжууд, ногдол ашгийн бодлогын тогтвортой хэрэгжилтийн талаар асуув.

Хариулт (Р.Мөнхтуяа): Ногдол ашгийн бодлогыг бид IPO хийхэд танилцуулсан ба жил бүр ашгийн төлөвлөгөөг биелүүлвэл 40-60 хувийг тараана гэсэн бодлоготой байна. Банкны Эрсдэл хариуцсан орлогч захирлын харьяанд 3 дэд захирал, 10 эрсдэлийн газар ажилладаг ба эрсдэлийн баг нь банканд учирч болзошгүй эрсдэлийг удирддаг. Банк 62 үндсэн, 37 дэд эрсдэлийг тодорхойлж эдгээрийг хариуцсан нэгжүүд олон улсын стандарт, аргачлалыг мөрдөн удирддаг. Мэдээлэл технологийн эрсдэл ихээхэн чухал болж байна. Гадны болон дотоод халдлага, хакер, үндсэн систем рүү нэвтрэх оролдлого хийсэн эсэхийг жилд 2 удаа олон улсын мэргэжлийн байгууллагаар шалгалт хийлгэж, илэрсэн асуудлыг хааж ажилладаг. Өнөөдрийг хүртэл томоохон учирсан эрсдэл байхгүй байна.

Асуулт №5: Зээлийн чанаргүйдэл, хугацаа хэтрэлтийн хувь, өмнөх оны өөрчлөлт? Google Pay, Apple Pay нэвтрүүлэх төлөвлөгөө байгаа эсэх, хувьцаагаа өөр улсын биржид dual-listing хийх үү?

Хариулт (Р.Мөнхтуяа): Өмнөх онтой харьцуулахад зээлийн багцын чанар хэвийн буюу нийт багцын хугацаа хэтрэлт 4.4 хувь байсан бол энэ жил 4.3 хувь болж буурсан. Төлбөр тооцооны хувьд банк Алипэйтэй холбогдож байна. ХААН Банк нь ритэйл банк буюу ТТХ болон зээлийн 70 орчим хувь нь иргэд, өрх, ЖДБ эрхлэгчид чиглэсэн байдаг. Эдгээр харилцагчдын нийтлэг хэрэгцээ нь Хятад улсад очоод төлбөр тооцоо хийх юм. Иймд бид Алипэйтэй хамтран Хятад улсад очиход бүх төлбөр тооцоогоо ХААН Банкнаар дамжжулан хийх боломжтой байхаар хамтран ажиллаж байна. Гуравт, ХААН Банк Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа гаргаад 3 дахь жилдээ явж байна. Манай банк гадаадын зах зээлд гарахын тулд Монголын хөрөнгийн биржийг хүлээн зөвшөөрсөн биржтэй хамтын ажиллагаатай байх ёстой тул ажиллаад явж байна. Иймд УИХ, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголбанктай хамтран гадны биржүүдэд очиж хамтын ажиллагаа сайжруулах, хүлээн зөвшөөрөөгдөх хүрээнд бүх банкуудтай хамтарч ажиллаж байна.

Асуулт хариулт, саналын хэсэг дуусав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн батлах асуудлуудаар санал хураахтай холбогдуулан Тооллогын Комиссын дарга Б.Онон 5 алхам бүхий зааварчилгааг танилцуулав.

Хурлын дарга Т.Дарьбум санал хураалтыг эхлүүлэв.

САНАЛ ХУРААЛТ:

1. “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
2. “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсөв;
3. “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг сонгон томилох.

Хурлын хөтөлбөрийн дагуу санал хураалтыг дуусгаж, Тооллогын Комисс хувьцаа эзэмшигчдийн саналыг нэгтгэв.

САНАЛ ХУРААЛТЫН ДҮН: Тооллогын Комиссын дарга Б.Онон хэлэлцэн батлах асуудлын санал хураалтын дүнг асуудал тус бүрээр танилцуулав. Үүнд:

1. “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.82 хувь буюу 1,645,704,555 ширхэг хувьцаатай 155 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99996 хувь зөвшөөрсөн, 0.00001 хувь татгалзсан, 0.00003 хувь түдгэлзсэн байна.

2. “ХААН Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.82 хувь буюу 1,645,704,555 ширхэг хувьцаатай 155 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99845 хувь зөвшөөрсөн, 0.00155 хувь татгалзсан, 0 хувь түдгэлзсэн байна.

3. “ХААН Банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.82 хувь буюу 1,645,704,555 ширхэг хувьцаатай 155 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Иший Кисабүро	9.29%	1,375,848,364
2	Харада Ясүнари	9.29%	1,376,408,307
3	Ц.Баатарсайхан	9.60%	1,421,225,347
4	Д.Хулан	9.61%	1,423,916,332
5	Б.Амарсанаа	13.22%	1,958,751,365
6	Жон Ло	13.23%	1,959,080,376

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Т.Дарьбум	11.92%	1,765,634,158
2	А.Тамир	11.92%	1,765,114,995
3	Ханс Аарт Йонгяанс	11.92%	1,765,361,751

Хурлын дарга Т.Дарьбум санал хураалтад оролцсон хувьцаа эзэмшигчдэд талархсанаа илэрхийлээд хурлаас гаргасан шийдвэрүүдийг уншиж танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг саналын дагуу батлав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг сонгон томилов.

Хэлэлцэх асуудал үүгээр дууссан тул 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 16:20 цагт өндөрлөв.

сөн: 

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

сөн:

Түлс: *З. Дарьвсан*

ХТҮ609

90270612

2693321

ХААН БАНК ХК

МОНГОЛ УЛС

ХТҮ609

Хурлын дарга